



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

Э-сонин

2-Р САР

55-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.02.28-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	19
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	2,727,423,225.62
Хувьцаа	1,782,431,575.62
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	925,691,650
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	19,300,000
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	3,182,769
Хувьцаа	3,182,176
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	9,741
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	193
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	3,618

Зах зээлийн үнэлгээ



TOP-20 индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	218
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	187
I ангилал	9
II ангилал	40
III ангилал	169
Ангилалдаагүй	0

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	58
Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

/2018.02.28-ний байдлаар/

Сим бол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард капитал групп ХХК	847,926	438,106,674.54	62,559	73,076,324.53	511,182,999.07
2	БиДиСек ХК	401,934	199,558,044.07	456,799	284,172,879.64	483,730,923.71
3	Голомт Капитал ХХК	432,682	242,725,448.60	384,981	208,886,318.13	451,611,766.73
4	Бумбат-Алтай ХХК	91,383	153,912,565.70	240,775	209,447,737.08	363,360,302.78
5	Стандарт инвестмент ХХК	258,224	135,770,045.97	629,176	195,668,764.50	331,438,810.47
6	Тулгат чандмань баян ХХК	245,258	99,950,585.00	253,462	109,778,953.50	209,729,538.50
7	Ти Ди Би Капитал ХХК	299,193	137,800,972.60	228,368	68,172,309.65	205,973,282.25
8	Ард секюритиз ХХК	84,758	59,083,027.84	250,574	90,563,111.97	149,646,139.81
9	Гаули ХХК	269,016	56,695,364.77	115,554	64,739,985.90	121,435,350.67
10	Блүмсбюри секюритиес ХХК	1,584	17,098,920.00	90,117	77,604,168.50	94,703,088.50
11	Новел инвестмент ХХК	58,874	31,970,147.75	154,167	59,649,478.58	91,619,626.33
12	Таван богд ХХК	40,907	28,699,390.00	40,959	46,313,238.00	75,012,628.00
13	Санар ХХК	11,823	727,073.30	57,214	41,363,514.30	42,090,587.60
14	Гүүдсек ХХК	2,077	1,415,525.00	10,202	35,589,361.98	37,004,886.98
15	Монсек ХХК	15,791	10,502,785.70	22,568	21,358,221.00	31,861,006.70
16	Гендекс ХХК	21	37,960.00	36,817	26,318,139.37	26,356,099.37
17	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	9,148	7,698,200.00	9,376	17,759,311.76	25,457,511.76
18	Гранддевелопмент ХХК	11,272	5,010,337.00	31,221	20,090,041.00	25,100,378.00
19	Лайфтайм инвестмент ХХК	23,423	22,582,775.00	2,873	1,250,890.00	23,833,665.00
20	BLUE SKY	2,517	16,748,410.00	400	2,637,895.00	19,386,305.00

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.02.28-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд	Доод	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	APU	АПУ	821,691	572,674,118.18	708.00	650.00	-15.79	-2.30
2	TTL	ТАВАН ТОЛГОЙ	33,050	357,844,280.00	12,520.00	10,000.00	10.00	0.10
3	GOV	ГОВЬ	8,046	191,734,600.00	25,500.00	22,600.00	-1,820.00	-7.38
4	BUK	УБ-БҮК	240,256	100,617,985.00	430.00	400.00	0.17	0.04
5	ITLS	АЙТҮҮЛС	497,611	70,659,458.00	162.00	120.00	-36.97	-23.40
6	JIV	ЖИНСТ-УВС	35,971	51,641,256.00	1,690.00	1,301.00	-290.00	-17.16
7	SUU	СҮҮ	208,936	47,153,903.30	258.00	200.00	-36.64	-14.43
8	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	9,295	43,100,915.00	4,637.00	4,637.00	604.00	14.98
9	BDS	БИ ДИ СЕК	29,582	35,452,761.00	1,219.00	1,130.00	-30.00	-2.54
10	HGN	ХӨХ ГАН	325,582	33,012,843.87	121.67	72.25	3.90	4.88
11	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	42,349	23,994,081.10	642.00	540.00	-90.41	-14.12
12	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	203,978	13,932,390.35	75.00	66.00	3.02	4.44
13	TCK	ТАЛХ ЧИХЭР	547	13,594,920.00	27,000.00	24,500.00	-300.00	-1.19
14	NEH	ДАРХАН НЭХИЙ	594	12,774,100.00	23,000.00	20,500.00	1,900.00	9.05
15	MRX	МЕРЕКС	337,649	11,327,085.00	39.00	31.00	-0.10	-0.31
16	GTL	ГУТАЛ	512	10,096,080.00	20,780.00	18,400.00	1,900.00	10.50
17	BAN	БАГАНУУР	4,473	9,284,503.00	2,250.00	1,901.00	-86.00	-4.12
18	MMX	МАХИМПЕКС	3,120	8,749,425.00	2,855.00	2,631.00	-218.00	-7.65
19	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	16,586	8,585,321.00	550.00	505.00	10.50	2.03
20	SHG	ШАРЫН ГОЛ	2,809	7,725,806.00	3,050.00	2,360.00	-510.00	-16.45



Үнэт цаасны зах зээл

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.02.28-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /	Өөрчлөлт ^{2,442.00} /%/
			2018-02-01	2018-02-28		
1	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	206	480.00	1,100.00	620.00	129.17
2	УВС ЧАЦАРГАНА	549	546.00	1,164.00	618.00	113.19
3	СОР	116	970.00	821.27	728.00	75.05
4	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	19	35.29	61.69	26.40	74.81
5	МОНГОЛ ШЕВРО	355	1,550.00	2442	892.00	57.55
6	МОН НАБ	208	2,300.00	3,500.00	1,200.00	52.17
7	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	22	332.21	217.25	172.79	52.01
8	ЖУУЛЧИН ГОВЬ	107	3,515.00	5,290.00	1,775.00	50.50
9	ГОНИР	1,545	460.00	653.00	193.00	41.96
10	СОНСГОЛОН БАРМАТ	113	621.00	821.27	200.27	32.25
11	ХӨВСГӨЛ ХҮНС	5	782.00	1,034.00	252.00	32.23
12	МОНГОЛ САВХИ	876	800.00	1,050.00	250.00	31.25
13	БАЯНТЭЭГ	233	11,000.00	14,000.00	3,000.00	27.27
14	СТАНДАРТ НООС	575	400.00	500.00	100.00	25.00
15	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	45	400.00	500.00	100.00	25.00
16	ХАСУ-МАНДАЛ	149	3,600.00	4,400.00	800.00	22.22
17	Е-МОНИЕ	6	716.79	872.73	155.94	21.76
18	ОЛОО	9,628	66.00	79.99	13.99	21.20
19	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	58	80,000.00	95,840.00	15,840.00	19.80
20	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	14	1,350.00	1,600.00	250.00	18.52

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.02.28-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-02-02	2018-02-28		
1	АЙТҮҮЛС	497,611	158.00	121.03	-36.97	-23.40
2	ЖИНСТ-УВС	35,971	1,690.00	1,400.00	-290.00	-17.16
3	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	10,974	239.78	200.00	-39.78	-16.59
4	ШАРЫН ГОЛ	2,809	3,100.00	2,295.00	-510.00	-16.45
5	ТАВ	114	17,830.00	25,000.00	-2,870.00	-16.10
6	ГАН ХИЙЦ	97	13,000.00	11,000.00	-2,000.00	-15.38
7	СҮҮ	208,936	253.89	217.25	-36.64	-14.43
8	МОНГОЛ ШУУДАН ХК	42,349	640.16	549.75	-90.41	-14.12
9	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	388	1,700.00	1,486.00	-214.00	-12.59
10	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	186	505.00	450.01	-54.99	-10.89
11	МОНГОЛ ШИЛТГЭЭН	233	440.00	400.00	-40.00	-9.09
12	МАХИМПЕКС	3,120	2,850.00	2,632.00	-218.00	-7.65
13	МОНГОЛ НЭХМЭЛ	52	5,950.00	5,495.00	-455.00	-7.65
14	ГОВЬ	8,046	24,660.00	22,840.00	-1,820.00	-7.38
15	Хархорин	59	1,900.00	1,780.00	-120.00	-6.32



"ЛЭНДМН ББСБ" ХХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдаж буй "Лэндмн ББСБ" ХХК-ийн нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800 сая ширхэг хувьцааг бүртгэж, нийт хувьцааны 25 хувь буюу 200 сая ширхэг хувьцааг тус бүр 25 төгрөгөөр худалдахыг зөвшөөрөв.

Тус компани "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан олон нийтэд 12.5 хувь буюу 100 сая ширхэг, тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчдад 12.5 хувь буюу 100 сая ширхэг хувьцаа арилжаалж нийт 5.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй бөгөөд үүнийг өөрийн үндсэн бүтээгдэхүүн болох хэрэглээний зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт зарцуулах юм. Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг "Мирэ эссет секьюритис Монгол" ХХК, аудитын үйлчилгээг "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг "Гэрэгэ эстимэйт" ХХК тус тус үзүүлж байна.

Нийт худалдаалах хувьцааны 80-аас дээш хувийг арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд худалдагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байна.

"ГОВЬ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн №4 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 220 / татварын өмнөх дүн/ төгрөг буюу нийт 1,716,247,500 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож гаргах бөгөөд ногдол ашгийг 2018 оны 4 сарын 24-ны өдрөөс эхлэн компани дээрээ бэлэн мөнгөөр олгох эсвэл хувьцаа эзэмшигчдэд хүссэн тохиолдолд харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2018 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн

"УЛААНБААТАР ХИВС" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Улаанбаатар хивс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн №4/2018 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоож 2018 оны 5 дугаар сарын 1-15-ны өдрийн хооронд ҮЦТХТ дэх хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар боллоо.

"ТАХЬКО" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Тахько" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн №1 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 108 төгрөг буюу нийт 128,518,164 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 5 сарын 01-ны дотор "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЖУРМУУД ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Арилжааны журам"-ын нэмэлт өөрчлөлт болон "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Үнэт цаасны индекс тооцох журам"-ын шинэчилсэн найруулгыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо батламжиллаа.

Ийнхүү шинэчлэн найруулсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" нь үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулж, бүртгэлийн ажиллагааг олон улсын нийтлэг практиктай нийцүүлсэн бол "Үнэт цаасны үнийн индекс тооцох журам"-д индексийн тооцоолуурыг нарийвчлан зохицуулж, ангиллын индекс тооцох зэрэг томоохон өөрчлөллүүдийг хийсэн. Мөн "Үнэт цаасны арилжааны журам"-д хаалтын ханшийг илүү бодитой тогтоох зорилгоор сүүлийн нэг цагийн арилжааны жигнэсэн дунджаар хаалтын ханшийг тогтоохоор тусгасан бөгөөд захиалгын шинэ төрлүүдийг идэвхжүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан юм.

Шинэчлэн найруулсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан журмуудыг хэрэгжүүлэх бэлтгэлийг яаралтай хангаж 2018 оны 02 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр болсон бөгөөд "Үнэт цаасны үнийн индекс тооцох журам"-д

"АДУУНЧУЛУУН" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Адуунчулуун" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн №2 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 130 төгрөг буюу нийт 409,669,520 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

"МОНГОЛ ШУУДАН" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Монгол Шуудан" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №18/01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс 30 хувиар тооцож хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 2.74 төгрөг буюу нийт 273,464,152.80 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 5 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн

"МАХИМПЭКС" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Махимпэкс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 100.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож 2018 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн бэлнээр компанийн байран дээр олгохоор шийдвэрлэсэн байна.

"ТАЛХ ЧИХЭР" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Талх Чихэр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 170.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийн өдөр болох 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтоож 2018 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн бэлнээр компанийн байран дээр олгохоор шийдвэрлэсэн байна.



ТОП-20 ИНДЕКСИЙН БАГЦ ШИНЭЧЛЭГДЭЖ, БҮРТГЭЛИЙН I БОЛОН II АНГИЛЛЫН ИНДЕКСҮҮД ТООЦОГДОЖ ЭХЭЛЛЭЭ

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдөр батламжилсан тул МХБ-ийн Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/15 тоот тушаалын дагуу ТОП-20 Индексийн сагсыг шинэ журмын дагуу дахин бүрдүүлж, тооцооллыг шинэчлэхийн хамтад бүртгэлийн I болон II ангиллын индексүүдийг тооцоолж эхэллээ.

ТОП-20 индексийн тооцоололд орсон гол өөрчлөлтүүд нь:

- Индексийн сагсыг жилд нэг удаа шинэчилдэг байх, улмаар ТОП-20 индексийг дагагч хөрөнгө оруулагчдын зардлыг бууруулах,

- Индексийн тооцоололд зөвхөн тухайн компанийн 5 ба түүнээс бага хувьтай тэнцэх хэмжээний үнэт цаас эзэмшигчдийн нийлбэр дүнг авч үзсэнээр индексийг олон нийтийн эзэмшлийн хувь /free-float/-д суурилан тооцоолох олон улсын жишигт нийцүүлэх,

- Тухайн үнэт цаасны индексэд үзүүлэх нөлөөг хязгаарлагч коэффициентыг улирлын давтамжтайгаар хянан, дахин тооцоолж байх зэрэг өөрчлөлтүүд болно.

Түүнчлэн, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны төслийн зөвлөмжийн дагуу бүртгэлийн шалгуураар ангилсан үнэт цаасны 2 индекс нэвтрүүлж байгаа болно. Энэ нь хөрөнгө оруулагч, арилжаанд оролцогчдод аль ангиллын компаниуд өсөлт, бууралттай байгааг харуулахаас гадна үнэт цаасны индексэд суурилсан бүтээгдэхүүн гаргах суурь нь болж байгаа юм. I ангиллын (MSE A Индекс) болон II ангиллын (MSE B Индекс) индексийг 2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлүүлж, эхлэлийн утгыг 10,000 нэгж байхаар нөхөн тооцоолсон бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE A Индекс нь 7,9%-ийн өсөлттэй, харин MSE B Индекс нь 0,8%-ийн өсөлттэй байна.

МХБ-ИЙН ШИНЭЧЛЭГДСЭН ЖУРМУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ БОЛЛОО

МХБ-ийн “Арилжааны журам”-ын нэмэлт, өөрчлөлт, “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам” болон “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр батламжилсан билээ. Эдгээр журмуудад орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах ажлын хүрээнд 02 дугаар сарын 15-ны өдөр зах зээлийн мэргэжлийн оролцогч нарт зориулсан танилцуулга, сургалт зохион байгууллаа.

Сургалтаар “Арилжааны журам”-д нэмэлтээр орсон арилжааны хаалтын ханшийг сүүлийн нэг цагийн дунджаар тогтоох, багцын арилжааны ханш дээд хязгааргүй байх, үнэт цаасны захиалгын бусдад харагдах тоо ширхгийг тогтоох функц, Бүхэлд нь даруй биелэгдэх эсвэл цуцлагдах захиалга /Fill or Kill/ болон “Минимумаас их дүнгээр биелэгдэх захиалга” /MinFill - худалдах, худалдан авах хамгийн бага тоо хэмжээг зааж өгөх бөгөөд заасан хэмжээнээс бага хэмжээгээр биелэгдэхгүй байх нөхцөлтэй захиалга/ зэрэг шинэ төрлийн захиалгын тодотголуудыг идэвхжүүлсэн зэрэг өөрчлөлтүүдийг сургалтад оролцогчдод танилцуулж, арилжааны програм дээр туршиж үзүүлэв.

Түүнчлэн, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д тусгагдсан үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалт, үнэт цаас гаргагч уул уурхайн компаниудад тавигдах шалгуур, шаардлагын шинэчлэлт, бүртгэлийн хураамжийн тооцооллыг зах зээлийн нийт үнэлгээнээс тооцохоор болсон тухай болон компанийн сайн засаглалыг дэмжих үүднээс нэгдүгээр ангиллын компаниудын үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн хураамж болон жилийн хураамжид хөнгөлөлт үзүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн үйл ажиллагаатай компаниудын бүртгэлийн хураамжийг хөнгөлөх зэрэг шинээр нэмж тусгасан өөрчлөлтүүдийг танилцууллаа. Мөн “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-д индексийн тооцооллыг нарийвчилсан зохицуулалт, үнэт цаасны I, II ангиллын индексүүдийг тооцож эхлэхээр болсон тухай дэлгэрэнгүй мэдээллийг өгөв.



“АПУ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“АПУ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн №18/05 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 10.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 06 дугаар сарын 01-ны өдөрт багтаан “ҮЦТХТ” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГЫН НЭЭЛТ, ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгын нээлт болон цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр болж өндөрлөлөө. Цан цохих үйл ажиллагаанд Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Бат-Очир, “Анд Глобал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Анар, “ЛэндМН ББСБ” ХК-ийн үүсгэн байгуулагч ТУЗ-ийн гишүүн О.Болдбаатар, болон “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Цэвэгмэд нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,665 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

“ЛэндМН ББСБ” ХК нь хиймэл оюун ухаанд суурилсан финтек /Fintech/ буюу цоо шинэ санхүүгийн бизнес моделийг Монголын улсын санхүүгийн салбарт 2016 онд анх удаа нэвтрүүлсэн компани бөгөөд өөрийн LendMN аппликейшнээр дамжуулан барьцаагүй, хямд өртөгтэй, хэрэглээний цахим зээлийн үйлчилгээг иргэдэд үзүүлдэг билээ. Тус компани нь Монголын банк бус санхүүгийн салбарыг төлөөлөн бүртгэгдэж буй анхны компани төдийгүй Монголын хөрөнгийн биржийн III дугаар ангилалд IPO хийж буй хамгийн анхны компани болж байгаагаараа

онцлог юм. Ийнхүү “ЛэндМН ББСБ” ХК нь стартап буюу шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, бизнесийн өсөлтийн мөчлөгтөө яваа жижиг, дунд компаниуд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож олон нийтийн компани болох томоохон боломж нээлттэй байдгийг харуулж байна.

“Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК” ХХК андеррайтер компаниар ажиллаж байгаа бөгөөд үнэт цаасны захиалгыг өнөөдрөөс эхлэн 2018 оны 3 дугаар сарын 07-ны өдөр хүртэл авна. Мөн ЛэндМН аппликейшнийг хэрэглэгчид гар утсаараа дамжуулан захиалгаа өгөх боломжтой юм.

“БАЯН ТЭЭГ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Баян Тээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн №05 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 06 дугаар сарын 01-ны өдөрт багтаан “ҮЦТХТ” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Баянгол зочид буудал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 355 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 09 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн компаниар дамжуулан бэлэн мөнгөөр тараахаар болсон байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN